



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/352

Арвайхээр сум

Газрын талбайн хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газар 13 дугаар баг Шинэ-Арвайхээр-3 гудамж, 326 тоотод байрлах худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай Ж.Аюуш (ЙЮ89101210)-ийн эзэмшил 401 м2 газрыг 610 м2 болгон эзэмшил газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхийн талбайн хэмжээ өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн "Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах тухай" А/220 дугаар захирамжийн хавсралтын Ж.Аюуштай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0680

D:My Doc. Zahiramj. Zasag darga